# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр Дугаар А/53 Сүхбаатар сум

Хуваарь батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан 2022 оны Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, хяналт шалгалтын удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2022 онд зохион байгуулах гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, бэлэн байдлын үзлэг, удирдах бүрэлдэхүүний сургалтын хуваарийг нэгдүгээр, Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын хуваарийг хоёрдугаар, гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, удирдах бүрэлдэхүүний сургалтад гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангаж, шаардлагатай хөрөнгийг цаг хугацаанд нь шийдвэрлэж, сургалт, дадлага сургуулийг үр дүнтэй зохион байгуулж ажиллах талаар аймгийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга, сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ө.Сувдаа)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тухай бүр ажлын хэсэг томилж шаардагдах зардлын тооцоог гаргаж шийдвэрлүүлж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Г.Галбадрах)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын дарга (Ц.Рэгзэдмаа)-т үүрэг болгосугай.

Н.ЛХАГВАДОРЖ

C:users/albanbichig2021/zahiramjA4.docx

430810152

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 11 -ны өдрийн А/53
тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

## ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ, УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Сум, гамшгаас хамгаалах алба, аж ахуй нэгжийн нэр | Төлөвлөсөн сар | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 1 | Алтанбулаг | | | | | АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ | | | | УС | ББ | | |
| 2 | Сүхбаатар | | | УС | ББ | | | | | | | | |
| 3 | Баянгол | | УС | ББ | | | | | | | | | |
| 4 | Баруунбүрэн | | | | | | | УС | ББ | | | | |
| 5 | Сант | | | | | | | УС | ББ | | | | |
| 6 | Сайхан | | УС | ББ | | | | | | | | | |
| 7 | Ерөө | | | | | | УС | ББ | | | | | |
| 8 | Орхон | | | | | | | | | | | | |
| 9 | Орхонтуул | | | | | | | | | | | | |
| 10 | Жавхлант | | | | | | УС | ББ | | | | | |
| 11 | Мандал | | УС | ББ | | | | | | | | | |
| 12 | Зүүнбүрэн | | | | | | | | | УС | ББ | | |
| 13 | Шаамар | | | | | | | | | УС | ББ | | |
| 14 | Цагааннуур | | | | | | | | | | УС | ББ | |
| 15 | Түшиг | | | | | | | | | | УС | ББ | |
| 16 | Хүдэр | | | | | | УС | ББ | | | | | |
| 17 | Хушаат | | | УС | ББ | | | | | | | | |
| 18 | Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба | | УС | ББ | | | | | | | | | |
| 19 | Эрүүл мэндийн алба | | | УС | ББ | | | | | | | | |
| 20 | Хүнс, хөдөө аж ахуйн алба | | | УС | ББ | | | | | | | | |
| 21 | Хэв журам сахиулах алба | | | УС | ББ | | | | | | | | |
| 22 | Мэргэжлийн болон цацрагын хяналтын алба | | УС | ББ | | | | | | | | | |
| 23 | Сурталчилгааны алба | | | УС | ББ | | | | | | | | |
| 24 | Зам тээврийн алба | | | УС | ББ | | | | | | | | |
| 25 | Түлш эрчим хүчний алба | | УС | ББ | | | | | | | | | |
| 26 | Мэдээлэл харилцаа холбооны алба | | | УС | ББ | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | Хүн ам, нийгмийн хамгааллын алба | | УС | ББ | | | | | | | | | |
| 28 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн алба | | УС | ББ | | АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ | | | | | | | |
| 29 | Барилга, хот байгуулалтын алба | | | УС | ББ | | | | | | | | |
| 30 | Санхүү хангалтын алба | | | УС | ББ | | | | | | | | |
| 31 | “Болд төмөр ерөө гол” ХХК | | УС | ББ | | | | | | | | | |
| 32 | “Бороо гоулд” ХХК | | УС | ББ | | | | | | | | | |
| 33 | “Тод ундрага” ХХК | | УС | ББ | | | | | | | | | |
| 34 | “Цемент Шохой” ХК | | УС | ББ | | | | | | | | | |
| 35 | УБТЗ-ын Сүхбаатар зангилаа | | | УС | ББ | | | | | | | | |
| 36 | Дархан-Сэлэнгэ ЦТС ХК | | | УС | ББ | | | | | | | | |
| 37 | "Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ | | | УС | ББ | | | | | | | | |
| 38 | “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК | | УС | ББ | | | | | | | | | |

**УС** – Удирдах бүрэлдэхүүний сургалт
**ББ** – Бэлэн байдлын үзлэг
**ИБ** – Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль

-o0o-